

# ЖОЛООЧИЙН ДААТГАЛЫН МЭДЭЭЛЛИЙН САНГИЙГ ЖУРАМ

## НЭГ. Нийтлэг үндэслэл

1.1 Энэхүү журмын зорилго нь Даатгалын тухай хуулийн 12.1.3.1, Жолоочийн даатгалын тухай хуулийн 24.1-д заасан жолоочийн даатгалын мэдээллийн санг үүсгэх, жолоочийн даатгалын мэдээллийг төвлөрүүлэн цуглуулах, хадгалах, харилцан солилцох, даатгагч, даатгуулагч, даатгалын тохиолдлын хохирогч, төрийн байгууллагуудыг шаардлагатай мэдээллээр хангахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

*/Энэ хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 1 дүгээр сарын 14-ний өдрийн 08 дугаар тогтоолоор нэмэлт оруулсан/*

1.2 Энэхүү журам нь Жолоочийн даатгалын тухай хууль тогтоомжийн хүрээнд мөрдөгдөнө.

## ХОЁР. Журамд хэрэглэгдэх нэр томъёоны тайлбар

2.1 Энэхүү журамд хэрэглэсэн нэр томъёог дараах утгаар ойлгоно:

2.1.1 “Холбогдох төрийн байгууллага” гэж Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх), Зам, тээврийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, Хууль зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, Санхүү, төсвийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, Цагдаагийн ерөнхий газар, Замын цагдаагийн газар, Гаалийн ерөнхий газар, Татварын ерөнхий газар, Хил хамгаалах ерөнхий газар, Улсын бүртгэлийн ерөнхий газар Гадаадын иргэн харьяатын алба зэрэг төрийн байгууллагыг;

*/Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 1 дүгээр сарын 14-ний өдрийн 08 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан/*

2.1.2 “Мэдээллийн сангийн программ хангамж” (цаашид “программ хангамж” гэх) гэж мэдээллийн сангийн үйл ажиллагааны зориулалтаар боловсруулсан албан ёсны программ хангамжийг;

2.1.3 “Мэдээллийн сангийн хэрэглэгч ”(цаашид “хэрэглэгч” гэх) гэж мэдээллийн сангийн программ хангамжид холбогдон ажиллах эрх олгогдсон Албан журмын даатгагчдын холбоо (цаашид “Холбоо” гэх), даатгагч, даатгалын зуучлагч, даатгуулагч, төрийн холбогдох байгууллагыг;

*/Энэ заалтад Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 1 дүгээр сарын 14-ний өдрийн 08 дугаар тогтоолоор нэмэлт оруулсан/*

2.1.4 “Стандарт” гэж мэдээллийн сан нь даатгагч, даатгалын зуучлагч болон төрийн холбогдох байгууллагуудын мэдээллийн сантай холбогдож цахим хэлбэрээр харилцан солилцох мэдээллийг бүтцийг.

*/Энэ заалтад Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 1 дүгээр сарын 14-ний өдрийн 08 дугаар тогтоолоор нэмэлт оруулсан/*

2.2 Энэхүү журамд тодорхойлоогүй нэр томъёог Монгол Улсын хуульд тодорхойлсноор ойлгоно.

### **ГУРАВ. Жолоочийн даатгалын мэдээллийн төрөл**

3.1. Хувь хүний мэдээлэлд дараах мэдээллийг хамруулна:

3.1.1 Иргэний харьяалал, овог, нэр, регистрийн дугаар, нас, хүйс, оршин суугаа газрын хаяг, холбоо барих утас, факс, и-мэйл хаяг;

3.1.2 Жолооны эрхийн үнэмлэхийн дугаар, ангилал, тээврийн хэрэгсэл жолоодох туршлага, мэргэшсэн жолоочийн эрхийн үнэмлэхийн дугаар болон бусад шаардлагатай мэдээлэл.

3.2 Хуулийн этгээдийн мэдээлэлд дараах мэдээллийг хамруулна:

3.2.1 Хуулийн этгээдийн оноосон нэр, улсын бүртгэлийн болон регистрийн дугаар, байршил, албан утас, факс, и-мэйл хаяг болон бусад шаардлагатай мэдээлэл.

3.3 Тээврийн хэрэгслийн мэдээлэлд дараах мэдээллийг хамруулна:

3.3.1 Тээврийн хэрэгслийн ангилал, гэрчилгээний дугаар, улсын дугаар, арлын дугаар;

3.3.2 Тээврийн хэрэгслийн үйлдвэр, марк, модель, зориулалт, үйлдвэрлэсэн он, өнгө, суудлын тоо, хөдөлгүүрийн багтаамж, даацын хэмжээ болон бусад шаардлагатай мэдээлэл.

3.4 Зам тээврийн осол, зөрчлийн мэдээлэлд дараах мэдээллийг хамруулна:

3.4.1 Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн зам тээврийн осол, зөрчил болсон газар нутгийн байршил, огноо, ослын шалтгаан, зам тээврийн осол гаргагч, хохирогчийн мэдээлэл болон бусад шаардлагатай мэдээлэл.

3.5 Даатгалын гэрээний мэдээлэлд дараах мэдээллийг хамруулна:

3.5.1 Даатгалын гэрээний дугаар, гэрээний хугацаа, итгэлцүүрийн утга, даатгалын хураамжийн дүн, даатгуулагчийн бүлэг болон бусад шаардлагатай мэдээлэл.

3.6 Даатгалын тохиолдол, нөхөн төлбөрийн мэдээлэлд дараах мэдээллийг хамруулна:

3.6.1 Холбоо болон даатгагчид бүртгэгдсэн даатгалын тохиолдол болсон газар нутгийн байршил, огноо, даатгалын тохиолдлын утга, даатгалын тохиолдол гаргагч, хохиролд орсон зүйл, хохирогчийн нэхэмжилсэн болон олгогдсон нөхөн төлбөрийн дүн болон бусад шаардлагатай мэдээлэл.

### **ДӨРӨВ. Мэдээллийн эх сурвалж**

4.1 Мэдээллийн санд төвлөрүүлэн нэгтгэсэн мэдээллийн үнэн зөв эсэхийг дараах этгээд

хариуцна:

*/Энэ хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 1 дүгээр сарын 14-ний өдрийн 08 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан/*

- 4.1.1 Жолоочийн даатгалд даатгуулагч хувь хүн болон хуулийн этгээдтэй байгуулсан даатгалын гэрээ, даатгалын тохиолдол, нөхөн төлбөрийн мэдээлэл болон бусад холбогдох мэдээллийг даатгагч;
- 4.1.2 Шуурхай албанд бүртгэгдсэн даатгалын тохиолдол, даатгалын сангаас олгосон нөхөн төлбөр, мэдээллийн сангаас олгосон лавлагаа, мэдээлэл болон бусад холбогдох мэдээллийг Холбоо;
- 4.1.3 Монгол Улсад бүртгэлтэй тээврийн хэрэгсэл болон түүний өмчлөгч, мэргэшсэн жолоочийн эрхийн мэдээллийг Зам тээврийн яам;
- 4.1.4 Зам тээврийн осол, зөрчлийн бүртгэл, Жолоочийн даатгалын хууль тогтоомж зөрчигчдийн мэдээлэл, жолооны эрхийн мэдээллийг Цагдаагийн ерөнхий газар, Замын цагдаагийн газар;
- 4.1.5 Дамжин өнгөрч байгаа болон түр хугацаагаар орж ирсэн автотээврийн хэрэгсэл, түүний өмчлөгч, жолоочийн мэдээллийг Хил хамгаалах ерөнхий газар (хилийн боомт);
- 4.1.6 Импортоор орж ирсэн болон экспортоор гарсан тээврийн хэрэгслийн мэдээллийг Гаалийн ерөнхий газар;
- 4.1.7 Иргэний болон хуулийн этгээдийн талаарх мэдээллийг Улсын бүртгэлийн ерөнхий газар;
- 4.1.8 Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварыг мэдээллийг Татварын ерөнхий газар;
- 4.1.9 Жолоочийн даатгалд даатгуулагч нь даатгалын зуучлагчаар дамжуулан даатгалын гэрээ байгуулсан бол энэ журмын 4.1.1-д заасан мэдээллийн тухайн даатгалын гэрээнд хамаарах хэсгийг даатгалын зуучлагч.

*/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 1 дүгээр сарын 14-ний өдрийн 08 дугаар тогтоолоор нэмсэн/*

#### **ТАВ. Мэдээллийн сан бүрдүүлэх**

- 5.1 Холбоо нь даатгагч болон даатгалын зуучлагч, төрийн холбогдох байгууллагаас жолоочийн даатгалын мэдээллийг хүлээн авах, харилцан мэдээлэл солилцох үйл ажиллагааг хамтран ажиллах гэрээний хүрээнд хийж гүйцэтгэнэ;

*/Энэ хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 1 дүгээр сарын 14-ний өдрийн 08 дугаар*

*тогтоолоор нэмэлт оруулсан/*

- 5.2 Даатгагчаас жолоочийн даатгалын мэдээлэл хүлээн авах маягт, стандартыг Хороогоор хянуулсны үндсэн дээр Холбоо батална;
- 5.3 Холбоо болон даатгагч жолоочийн даатгалын мэдээллийг дор дурдсан хугацаанд мэдээллийн санд хүргүүлнэ:
- 5.3.1 Даатгагч, даатгалын зуучлагч хувь хүн, хуулийн этгээд болон мэргэшсэн, С, D ангиллын жолоочтой байгуулсан, Монгол улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх болон түр хугацаагаар орж ирж байгаа автотээврийн хэрэгслийн жолоочийн даатгалын гэрээний мэдээллийг тухай бүр энэхүү журмын 5.2-т заасан маягт, стандартын дагуу боловсруулан цахим хэлбэрээр;  
*/Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 1 дүгээр сарын 14-ний өдрийн 08 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан/*
- 5.3.2 Даатгагч хохирогчид олгосон нөхөн төлбөрийн мэдээллийг тухайн өдөрт нь энэхүү журмын 5.2-т заасан маягт, стандартын дагуу боловсруулан цахим хэлбэрээр;
- 5.3.3 Даатгагч, даатгалын зуучлагч цуцлагдсан болон нэмэлт, өөрчлөлт орсон жолоочийн даатгалын гэрээний мэдээллийг тухайн өөрчлөлт орсон өдрөөс хойш ажлын 3 хоногт багтаан энэхүү журмын 5.2-т заасан маягт, стандартын дагуу боловсруулан цахим хэлбэрээр;  
*/Энэ заалтад Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 1 дүгээр сарын 14-ний өдрийн 08 дугаар тогтоолоор нэмэлт оруулсан/*
- 5.3.4 Даатгагч 1 сар хүртэлх хугацаатайгаар байгуулагдсан жолоочийн даатгалын гэрээний мэдээллийг тухай бүр энэхүү журмын 5.2-т заасан маягт, стандартын дагуу боловсруулан цахим хэлбэрээр;  
*/Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 1 дүгээр сарын 14-ний өдрийн 08 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан/*
- 5.3.5 Даатгагч, даатгалын зуучлагч даатгуулагчийн нөхөн төлбөр авсан тооноос хамааруулан даатгалын хураамжийн хэмжээг өсгөж хийсэн гэрээг энэхүү журмын 5.2-т заасан маягт, стандартын дагуу боловсруулан тухайн өдөрт нь цахим хэлбэрээр;  
*/Энэ заалтад Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 1 дүгээр сарын 14-ний өдрийн 08 дугаар тогтоолоор нэмэлт оруулсан/*
- 5.3.6 Даатгагч, даатгалын зуучлагчийн жолоочийн даатгалын үйл ажиллагаанд ашиглагдаж буй программ хангамж нь мэдээллийн сантай холбогдсон тохиолдолд жолоочийн даатгалын гэрээ, гэрээтэй холбогдох мэдээллийг тухайн өдөрт нь энэхүү журмын 5.2-т заасан маягт, стандартын дагуу боловсруулан цахим хэлбэрээр;

*/Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 1 дүгээр сарын 14-ний өдрийн 08 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан/*

- 5.3.7 Холбоо шуурхай албанд бүртгэгдсэн даатгалын тохиолдол, даатгалын сангаас хохирогчид олгогдсон болон буцаан нэхэмжилсэн нөхөн төлбөрийн мэдээллийг энэхүү журмын 5.2-т заасан маягт, стандартын дагуу боловсруулан цахим хэлбэрээр тухай бүр.
- 5.4 Төрийн холбогдох байгууллагууд болон даатгалын зуучлагч энэхүү журмын 5.1-д заасан гэрээнд тусгасан мэдээллийг цахим хэлбэрээр тухай бүр мэдээллийн санд нийлүүлнэ;  
*/Энэ хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 1 дүгээр сарын 14-ний өдрийн 08 дугаар тогтоолоор нэмэлт оруулсан/*
- 5.5 Холбоо даатгагч болон даатгалын зуучлагч, төрийн холбогдох байгууллагуудтай жолоочийн даатгалын мэдээллийг программ хангамжийн тусламжтайгаар харилцан солилцож болно;  
*/Энэ хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 1 дүгээр сарын 14-ний өдрийн 08 дугаар тогтоолоор нэмэлт оруулсан/*
- 5.6 Мэдээллийн сан дахь жолоочийн даатгалын гэрээний мэдээлэл нь өөрчлөн шинэчлэгдэх үед шинээр орж буй өөрчлөлт нь хураамжийн дүнд нөлөөлөхүйц байвал өөрчлөлтийн өмнөх мэдээлэл нь түүх болж хадгалагдана.

#### **ЗУРГАА. Мэдээллийн сангийн үйл ажиллагаа**

- 6.1 Холбоо нь мэдээллийн сангийн дараах үйл ажиллагааг эрхэлнэ:
- 6.1.1 Жолоочийн даатгалын мэдээллийг энэхүү журмын 4 дүгээр зүйлд заасан этгээдээс төвлөрүүлэн нэгтгэж мэдээллийн санг үүсгэх, ашиглах;
- 6.1.2 Жолоочийн даатгалын гэрээ, даатгалын тохиолдол, нөхөн төлбөрийн мэдээлэлд хяналт тавих замаар Жолоочийн даатгалын тухай хуулийн үнэн, зөв, бодитой хэрэгжилтийг хангах;
- 6.1.3 Даатгуулагчийн жолоочийн даатгалын гэрээн дэх бүлэг, нөхөн төлбөр авсан тоо, худал мэдүүлсэн тоог бүртгэх;
- 6.1.4 Мэдээллийн сангийн мэдээллийг даатгагч, даатгалын зуучлагч болон төрийн холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах гэрээний дагуу харилцан солилцох, харьцуулан шалгах, шинэчлэх;  
*/Энэ заалтад Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 1 дүгээр сарын 14-ний өдрийн 08 дугаар тогтоолоор нэмэлт оруулсан/*
- 6.1.5 Мэдээллийн сангаас лавлагаа, мэдээлэл өгөх:
- 6.1.5.1 Холбоо мэдээллийн сангаас мэдээлэл, лавлагаа хүсэгчид Жолоочийн даатгалын тухай хуулийн 24.4, 24.5, 24.6-д заасны дагуу лавлагаа, мэдээллийг олгоно;

*/Энэ заалтад Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 1 дүгээр сарын 14-ний өдрийн 08 дугаар тогтоолоор нэмэлт оруулсан/*

6.1.5.2 даатгуулагчийн сүүлийн 3 жил хүртэлх жолоочийн даатгалын түүх, мэдээллийг лавлагаанд тусгаж болно;

6.1.5.3 даатгагч, даатгалын зуучлагч, даатгуулагч болон төрийн холбогдох байгууллага нь мэдээллийн санд алдаатай мэдээлэл нийлүүлснээс учирсан аливаа хохирлыг мэдээллийн сангаас лавлагаа, мэдээлэл олгогдсон эсэхээс үл хамааран Холбоо хариуцахгүй.

*/Энэ заалтад Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 1 дүгээр сарын 14-ний өдрийн 08 дугаар тогтоолоор нэмэлт оруулсан/*

6.1.6 Мэдээллийн сангийн мэдээллийг боловсруулж тайлан судалгаа, бусад бүтээгдэхүүн болгон гаргах.

6.2 Холбоо нь энэхүү журмын 6.1-д заасан мэдээллийн сангийн үйл ажиллагааг эрхлэхдээ программ хангамж, техник, тоног төхөөрөмж ашиглана;

6.3 Мэдээллийн санд ашиглагдах программ хангамж, техник, тоног төхөөрөмжийн хэвийн, найдвартай, тасралтгүй ажиллагааг Холбоо хариуцна;

6.4 Мэдээллийн сангийн программ хангамжид нэвтрэх, ажиллах эрх бүхий хэрэглэгчийн бүртгэлийг Холбоо хөтөлж, үйл ажиллагаанд нь хяналт тавина;

6.5 Мэдээллийн сангийн үйл ажиллагаанд дараах зүйлийг хориглоно:

6.5.1 Холбооны ажилтан, эрх бүхий албан тушаалтан болон програм хангамжид нэвтрэх эрх бүхий этгээд нь Төрийн нууцын тухай, Төрийн нууцын жагсаалт батлах тухай, Байгууллагын нууцын тухай, Хувь хүний нууцын тухай хуулиар нууцад хамааруулсанаас гадна өөр бусад байдлаар төр, байгууллага, хувь хүний нууцад хамаарах аливаа мэдээ, мэдээллийг хуульд нийцээгүй, зөвшөөрөөгүй хэлбэрээр ашиглах, бусдад тараах, задруулах;

*/Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 1 дүгээр сарын 14-ний өдрийн 08 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан/*

6.5.2 Холбоо, даатгагч, даатгалын зуучлагч, даатгуулагч, төрийн холбогдох байгууллага нь мэдээллийн санд жолоочийн даатгалын мэдээллийг санаатайгаар алдаатай нийлүүлэх, солилцох, мэдээлэх;

*/Энэ заалтад Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 1 дүгээр сарын 14-ний өдрийн 08 дугаар тогтоолоор нэмэлт оруулсан/*

6.5.3 Мэдээллийн сангийн үйл ажиллагааны талаар буруу, ташаа зар сурталчилгаа явуулах, мэдээлэл өгөх;

6.5.4 Мэдээллийн сангийн мэдээллийг Холбооны зөвшөөрөлгүйгээр хуулбарлах, ашиглах, Монгол Улсаас авч гарах, гадаад улсад шилжүүлэх;

6.5.5 Мэдээллийн сангийн аливаа мэдээллийг хувилан тараах, худалдан борлуулах, ухуулга сурталчилгааны болон бусад нэр төр, ажил хэргийн нэр хүндэд халдах зорилгоор ашиглах.

*/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 1 дүгээр сарын 14-ний өдрийн 08 дугаар тогтоолоор нэмсэн/*

6.6 Мэдээллийн сангийн мэдээллийг хадгалах, хамгаалах, аюулгүй байдлыг хангах:

6.6.1. Жолоочийн даатгалын мэдээллийг мэдээллийн санд хүлээн авсан өдрөөс хойш 10 жилийн хугацаанд хадгална;

6.6.2. Холбоо мэдээллийн санд хадгалагдаж буй мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангаж баталгаажуулна;

6.6.3. Мэдээллийн сангийн нууцлал, хамгаалалтыг хангаагүйн улмаас учирсан болон энэ журмын 8.2.11-т дурдсан гэм буруутай ажилтны учруулсан хохирлыг Холбоо хариуцна;

*/Энэ заалтад Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 1 дүгээр сарын 14-ний өдрийн 08 дугаар тогтоолоор нэмэлт оруулсан/*

6.6.4. Мэдээллийн сангийн программ хангамжид нэвтрэх эрх бүхий ажилтны буруутай үйл ажиллагаанаас мэдээллийн сангаас мэдээлэл алдагдах, программ хангамжийг гэмтээх, мэдээллийн сангийн аюулгүй байдалд хохирол учруулсан тохиолдолд учруулсан хохирлыг тухайн ажилтан болон түүний харьяалагдах байгууллага нь бүрэн хариуцна;

6.6.5. Холбооны эрх бүхий ажилтан мэдээллийн сангийн цахим өгөгдлийг долоо хоног бүр, шаардлагатай тохиолдолд тухай бүр нөөцлөн, архивлаж /backup/ холбогдох бүртгэл хөтөлнө;

*/Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 1 дүгээр сарын 14-ний өдрийн 08 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан/*

6.6.6. Холбоо мэдээллийн сангийн цахим өгөгдлийг хадгалж буй сервер компьютер, тоног төхөөрөмжийг өөрийн байранд болон мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас баталсан журмын дагуу “Үндэсний дата төв” УТҮГ-т зориулалтын дагуу тус тус байршуулна;

*/Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 1 дүгээр сарын 14-ний өдрийн 08 дугаар тогтоолоор нэмсэн/*

6.6.7. Програм хангамж нь энэ журмын 6.6.6.-д заасан сервер компьютерүүдтэй нэгэн зэрэг

шууд холбогдон ажиллах боломжтой байх ба дараах үндсэн шаардлагуудыг хангасан байна. Үүнд:

*/Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 1 дүгээр сарын 14-ний өдрийн 08 дугаар тогтоолоор нэмсэн/*

- 6.6.7.1. мэдээллийн сан руу хандсан хандалтын түүх /log/-ийг “Үндэсний дата төв” УТҮГ-т байрлаж буй серверээс ямарч тохиолдолд устгах болон өөрчлөлт оруулах боломжгүйгээр програмчлагдсан байх;
  - 6.6.7.2. програм хангамж нь хэрэглэгч бүрийн хандалтын түүх, мэдээллийн урсгал, сервер компьютерүүдийн санах ойн сул зай, мэдээллийн санд хадгалагдсан бүх мэдээллийн тоо, хэмжээ зэрэг мэдээллийг багтаасан тайлан /report/-г долоо хоног бүр автоматаар гарган цахим хэлбэрээр сервер компьютерт хадгаладаг байх;
  - 6.6.7.3. програм хангамжид нэвтрэн ажиллаж байгаа хэрэглэгчийн тооноос үл хамааран гацалтгүй, найдвартай ажиллагаатай байх, гацалт үүссэн нөхцөлд мэдээллийн нууцлал, бүрэн бүтэн аюулгүй байдлыг хангасан нөөц серверт холбогдон ажиллах боломжтой байх;
  - 6.6.7.4. гадны хандлагаас сэргийлэх өндөр түвшний хамгаалалттай байх;
  - 6.6.7.5. програм хангамжийг системийн ачаалал даах чадвар, гадны хандлагаас сэргийлэх систем, мэдээллийн санд их хэмжээний өгөгдөл хадгалах боломж зэргийг мэргэжлийн байгууллага эсхүл Холбооны дотоод нөөц бололцоогоор шалгаж тестлэсэн байна.
- 6.6.8. Мэдээллийн сангийн цахим нөөц мэдээлэл, програм хангамж, сервер компьютерийн үйлдлийн систем нь сүүлийн үеийн, олон улсад түгээмэл ашиглагддаг, өндөр түвшний хамгаалалт бүхий ашиглалтын албан ёсны эрхтэй өгөгдлийн сан, програмчлалын хэл дээр бүтээгдсэн байна.
- /Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 1 дүгээр сарын 14-ний өдрийн 08 дугаар тогтоолоор нэмсэн/*
- 6.6.9. Програм хангамжийн эх код /source code/-ыг Хороонд цахим хэлбэрээр хадгалах бөгөөд Холбоо програм хангамжийн үйл ажиллагааг шинэчлэн өөрчлөх, сайжруулах зорилгоор эх кодоод өөрчлөлт оруулах тохиолдолд Хорооноос зөвшөөрөл авна.



*/Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 1 дүгээр сарын 14-ний өдрийн 08 дугаар тогтоолоор нэмсэн/*

6.6.10. Програм хангамжид дараах 4 түвшний хэрэглэгчийн эрхээр нэвтэрнэ:

*/Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 1 дүгээр сарын 14-ний өдрийн 08 дугаар тогтоолоор нэмсэн/*

- 6.6.10.1. нэгдүгээр түвшин: “Админ эрх” – энэ хэрэглэгчийн эрх нь ганц байх ба нэвтрэх нэр, нууц үг нь зөвхөн Хорооны Даатгалын газрын даргад хадгалагдаж, албан хэрэгцээнд зөвхөн мэдээллийн сангаас хайлт хийх, II түвшний хэрэглэгчийн эрхийг түр хаах, буцаан нээх, нууц үгийн солих эрхтэй байна;
- 6.6.10.2. хоёрдугаар түвшин: “Мэдээллийн сангийн зохицуулагчийн эрх” – энэ хэрэглэгчийн эрх нь Холбоонд хадгалагдаж, мэдээллийн сан, програм хангамжийн өдөр тутмын найдвартай ажиллагааг ханган ажиллаж, дараагийн түвшний эрхүүдийг програм хангамжийн хүрээнд удирдан, өөртэйгээ ижил түвшний хэрэглэгчийн эрх шинээр үүсгэх, устгах тохиолдолд I түвшний хэрэглэгчийн эрх бүхий этгээдээс бичгээр зөвшөөрөл авна;
- 6.6.10.3. гуравдугаар түвшин: “Хэрэглэгчийн түвшний админ эрх” – энэ эрх нь мэдээллийн сангийн програм хангамжид нэвтрэх эрх бүхий даатгагч, даатгалын зуучлагч тус бүрт 1 байх ба дараагийн шатны хэрэглэгчийн эрхийг шинээр үүсгэхээс гадна, ажлын цагийг өөрийн салбар нэгжийн ажиллах цагийн хуваарьтай уялдуулан тохируулах, 7.1 – т заасан хамтран ажиллах гэрээний хүрээнд мэдээлэл нийлүүлэх, солилцох, ашиглах эрхтэй байна;
- 6.6.10.4. дөрөвдүгээр түвшин: “Хэрэглэгчийн эрх” – энэ эрх нь зөвхөн журмын 7.1-т заасан хамтран ажиллах гэрээний хүрээнд мэдээлэл нийлүүлэх, солилцох, ашиглах эрхтэй байна.

#### **ДОЛОО. Хамтран ажиллах гэрээний нөхцөл**

7.1 Холбоо нь даатгагч, даатгалын зуучлагч болон холбогдох төрийн байгууллагуудтай байгуулах мэдээлэл нийлүүлэх, харилцан солилцох, ашиглах, хамтран ажиллах гэрээнд дараах нөхцлийг заавал тусгана:

*/Энэ хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 1 дүгээр сарын 14-ний өдрийн 08 дугаар тогтоолоор*

*нэмэлт оруулсан/*

- 7.1.1 Гэрээ байгуулж байгаа талуудын нэр, хаяг, регистр, холбоо барих утас;
- 7.1.2 Гэрээний хугацаа, гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээ цуцлах, дуусгавар болгох, хүчингүй болгох нөхцлүүд;
- 7.1.3 Харилцан солилцох мэдээлэл, түүний бүтэц;
- 7.1.4 Мэдээлэл нийлүүлэх, ашиглах хугацаа;
- 7.1.5 Мэдээллийн нууцлалыг хадгалах, эрх олгогдоогүй этгээдэд задруулахгүй байх, үүргээ биелүүлээгүйгээс учирсан хохирлыг хэрхэн барагдуулах, хүлээх хариуцлагын талаар;
- 7.1.6 Гэрээний талуудын эрх, үүрэг;
- 7.1.7 Гомдол гаргах, маргаан шийдвэрлэх талаар;
- 7.1.8 мэдээлэл ашиглахад төлбөр төлөх эсэх, төлбөртэй бол төлбөрийг хэрхэн тооцох талаар.

*/Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 1 дүгээр сарын 14-ний өдрийн 08 дугаар тогтоолоор нэмсэн/*

### **НАЙМ. Холбооны эрх, үүрэг**

#### **8.1 Холбоо дараах эрхтэй:**

- 8.1.1 Жолоочийн даатгалын мэдээллийн сангийн үйл ажиллагаа эрхлэх;
- 8.1.2 Даатгагч, даатгалын зуучлагч холбогдох төрийн байгууллагын нийлүүлж байгаа мэдээллийг хянан үзсэний үндсэн дээр мэдээллийн санд оруулах, бүрэн бус, эргэлзээтэй, тодорхойгүй мэдээллийг нягтлан шалгаж, шаардлага хангаагүй мэдээг хүлээн авахаас татгалзах, энэхүү журмын 5.3, 5.4-т заасан хугацаанд мэдээллээ нийлүүлэх, алдаатай мэдээллийг дахин ирүүлэхийг шаардах;  
*/Энэ заалтад Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 1 дүгээр сарын 14-ний өдрийн 08 дугаар тогтоолоор нэмэлт оруулсан/*
- 8.1.3 Даатгагч, даатгалын зуучлагч нь жолоочийн даатгалын мэдээллийг удаа дараа хоцроосон тохиолдолд шаардлагатай арга хэмжээг хууль, журмын дагуу авах саналыг Хороонд хүргүүлэх, сангаас лавлагаа, мэдээлэл авах эрхийг хязгаарлах;  
*/Энэ заалтад Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 1 дүгээр сарын 14-ний өдрийн 08 дугаар тогтоолоор нэмэлт оруулсан/*
- 8.1.4 Хамтран ажиллах гэрээ байгуулсан этгээд нь мэдээллийн сангийн мэдээллийг хэрхэн ашиглаж байгаа талаар тайлбар авах, хяналт тавих;
- 8.1.5 Холбооны гишүүн бус байгууллагын мэдээллийн сангаас авч ашигласан лавлагаа, мэдээллийн төлбөрийг энэ журмын 6.1.5.1 – т заасны дагуу болон 7.1.8 – т заасан

хамтран ажиллах гэрээний нөхцлөөр төлөхийг шаардаж төлүүлэх.

*/Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 1 дүгээр сарын 14-ний өдрийн 08 дугаар тогтоолоор нэмсэн/*

## 8.2 Холбоо дараах үүрэгтэй:

8.2.1 Жолоочийн даатгалын мэдээллийн санг үнэн зөв, бүрэн гүйцэд бүрдүүлэх, хөтлөх, хамгаалах, мэдээлэх, холбогдох хууль, журмын дагуу өөрчлөлт шинэчлэлтийг хийх, боловсруулах;

8.2.2 Мэдээллийн сангийн хэвийн ажиллагаа, аюулгүй байдлыг хангах, нууцлалыг хангахтай холбогдсон шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

8.2.3 Мэдээллийн сангаас тайлан, мэдээ гаргах, судалгаа, дүн шинжилгээ хийх, ашиглах, холбогдох байгууллагуудад хүргүүлэх;

8.2.4 Хамтран ажиллах гэрээ байгуулсан даатгагч, даатгалын зуучлагчид мэдээллийн сангийн программ хангамжид нэвтрэх эрх олгох, хэрэглэгчээр бүртгэх, эрхийн зохицуулалтыг хэрэгжүүлэх;

*/Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 1 дүгээр сарын 14-ний өдрийн 08 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан/*

8.2.5 Даатгагч, даатгалын зуучлагч болон төрийн холбогдох байгууллагатай хамтран ажиллах гэрээний дагуу харилцан солилцсон мэдээллийн бүртгэлийг хөтлөх, баталгаажуулах;

*/Энэ заалтад Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 1 дүгээр сарын 14-ний өдрийн 08 дугаар тогтоолоор нэмэлт оруулсан/*

8.2.6 Мэдээллийн сангаас лавлагаа, мэдээлэл олгох, бүртгэл хөтлөх;

8.2.7 Даатгагч болон даатгалын сангаас хохирогчид олгосон нөхөн төлбөрийн мэдээллийг холбогдох журмын дагуу цагдаагийн байгууллагад цахим хэлбэрээр хүргүүлэх;

8.2.8 Жолоочийн даатгалд хамрагдаагүй тээврийн хэрэгсэл, өмчлөгчийг илрүүлэн гаргах;

8.2.9 Даатгагч, даатгалын зуучлагч, даатгуулагч, төрийн байгууллагын нууцад хамаарах мэдээллийг бусдад задруулахгүй байх;

*/Энэ заалтад Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 1 дүгээр сарын 14-ний өдрийн 08 дугаар тогтоолоор нэмэлт оруулсан/*

8.2.10 Мэдээллийн сангийн үйл ажиллагатай холбогдсон хууль, хяналтын байгууллагаас гаргасан шаардлага, зохицуулалтыг хэрэгжүүлэх;

8.2.11 Холбооны ажилтан нь энэхүү журмаар хориглосон мэдээллийг мэдээллийн санд нийлүүлсэн, даатгуулагчийн нууцад хамаарах мэдээллийг бусдад задруулсан бол гэм буруутай ажилтанд Холбооны дотоод журмын дагуу хариуцлага хүлээлгэх.

## ЕС. Даатгагч, даатгалын зуучлагчийн эрх, үүрэг

### 9.1 Даатгагч, даатгалын зуучлагч нь дараах эрхтэй:

*/Энэ хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 1 дүгээр сарын 14-ний өдрийн 08 дугаар тогтоолоор нэмэлт оруулсан/*

- 9.1.1 Мэдээллийн санд нийлүүлсэн мэдээлэл нь өөрчлөгдөх, худал, алдаатай нэмэлт мэдээлэл оруулахгүй байхад хяналт тавих;
- 9.1.2 Өөрийн нийлүүлсэн мэдээллийн эх сурвалжид эргэлзээтэй байдал үүссэний улмаас уг мэдээллийг тодруулах, нягтлан шалгах зайлшгүй шаардлага гарсан тохиолдолд даатгуулагч болон холбогдох байгууллагуудад хүсэлт гаргаж, шийдвэрлүүлэх;
- 9.1.3 Жолоочийн даатгалын үйл ажиллагаандаа ашиглах лавлагаа, мэдээллийг мэдээллийн сангаас үнэ төлбөргүй авах.

### 9.2 Даатгагч, даатгалын зуучлагч нь дараах үүрэгтэй:

*/Энэ хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 1 дүгээр сарын 14-ний өдрийн 08 дугаар тогтоолоор нэмэлт оруулсан/*

- 9.2.1 Холбоотой байгуулсан хамтран ажиллах гэрээнд заасан үүргээ биелүүлэх;
- 9.2.2 Жолоочийн даатгалын мэдээллийг энэхүү журмын 5.3.1-5.3.6-д заасан хугацаанд мэдээллийн санд нийлүүлэх;
- 9.2.3 Жолоочийн даатгалын мэдээллийн үнэн зөв эсэхийг нягтлан шалгасны үндсэн дээр мэдээллийн санд нийлүүлэх;
- 9.2.4 Мэдээллийн санд нийлүүлсэн мэдээлэл алдаатай болон бүрэн гүйцэд биш шалтгаанаар мэдээллийн сангаас буцаагдсан тохиолдолд тухай бүр дахин засварлаж нийлүүлэх;  
*/Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 1 дүгээр сарын 14-ний өдрийн 08 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан/*
- 9.2.5 Даатгагч нь мэдээллийн санд нийлүүлсэн жолоочийн даатгалын гэрээний нийт хураамжийн дүн, хохирогчид олгогдсон нөхөн төлбөрийн нийт дүн нь өөрт бүртгэгдсэн дүнтэй тохирч байгаа эсэхэд хяналт тавих;  
*/Энэ заалтад Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 1 дүгээр сарын 14-ний өдрийн 08 дугаар тогтоолоор нэмэлт оруулсан/*
- 9.2.6 Мэдээллийн санд мэдээлэл тогтмол нийлүүлэх үйл ажиллагааг хариуцсан мэдээллийн сангийн бүртгэлийн ажилтанг томилох, тухайн ажилтны мэдээллийг Холбоонд хүргүүлж, хэрэглэгчээр бүртгүүлэх, программ хангамжид нэвтрэх, ажиллах эрх авах, нууцын баталгаа гаргах;

- 9.2.7 Даатгагчийн мэдээллийн сангийн бүртгэлийн ажилтан өөрчлөгдөх тухай бүр шинэ ажилтныг томилон тухайн ажилтны холбогдох мэдээллийг ажлын 3 өдөрт багтаан Холбоонд хүргүүлэх;
- 9.2.8 Мэдээллийн сангаас олгогдож буй даатгуулагчийн талаарх лавлагаа, мэдээллийг бусдад задруулахгүй байх.
- 9.2.9 Даатгалын зуучлагч нь мэдээллийн санд нийлүүлсэн жолоочийн даатгалын гэрээний нийт хураамжийн дүн нь өөрт бүртгэгдсэн дүнтэй тохирч байгаа эсэхэд хяналт тавих.

*/Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 1 дүгээр сарын 14-ний өдрийн 08 дугаар тогтоолоор нэмсэн/*

### **АРАВ. Даатгуулагчийн эрх, үүрэг**

#### 10.1 Даатгуулагч дараах эрхтэй:

- 10.1.1 Мэдээллийн сангаас олгогдох лавлагаа, мэдээлэл нь үнэн зөв, бодитой, эх сурвалжид нийцсэн мэдээлэл агуулсан байхыг шаардах;
- 10.1.2 Мэдээллийн сан дахь даатгуулагчийн мэдээлэл нь алдаатай бол нэн даруй засварлах, шинэчлэхийг Холбоо, даатгагч, даатгалын зуучлагчаас шаардах;  
*/Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 1 дүгээр сарын 14-ний өдрийн 08 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан/*
- 10.1.3 Мэдээллийн сангийн нийтэд ашиглуулах програм хангамжаар өөрийн даатгалын мэдээлэлд хяналт тавих.  
*/Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 1 дүгээр сарын 14-ний өдрийн 08 дугаар тогтоолоор нэмсэн/*

#### 10.2 Даатгуулагч дараах үүрэгтэй:

- 10.2.1 Даатгуулагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч нь мэдээллийн сангийн лавлагаанд тусгагдсан мэдээллийн нууцыг хадгалах, гуравдагч этгээдэд дамжуулахгүй байх;
- 10.2.2 Мэдээллийн сангийн лавлагаанд тусгагдсан мэдээлэл алдаатай болохыг мэдсэн бол энэ талаар даатгагч болон Холбоонд нэн даруй мэдэгдэн өөрчлөлт оруулах.

### **АРВАН НЭГ. Төрийн холбогдох байгууллагын эрх, үүрэг**

#### 11.1 Төрийн холбогдох байгууллага дараах эрхтэй:

- 11.1.1 Хамтран ажиллах гэрээ байгуулсны үндсэн дээр харилцан мэдээлэл солилцохыг Холбооноос шаардах;
- 11.1.2 Жолоочийн даатгалын мэдээллийг хамтран ажиллах гэрээнд заасан нөхцлийн дагуу боловсруулж ирүүлэхийг Холбооноос шаардах.

#### 11.2 Төрийн холбогдох байгууллага дараах үүрэгтэй:

11.2.1 Жолоочийн даатгалын тухай хууль болон холбогдох бусад журмаар хүлээсэн үүргээ биелүүлэх;

11.2.2 Хамтран ажиллах гэрээнд заасан нөхцлийн дагуу үнэн зөв бодитой мэдээллийг тухай бүр мэдээллийн санд нийлүүлэх, харилцан солилцох, гэрээний үүргээ биелүүлэх;

11.2.3 Даатгуулагчийн нууцад хамаарах мэдээллийг бусдад задруулахгүй байх.

### **АРВАН ХОЁР. Хяналт, хариуцлага**

12.1 Холбоо энэхүү журмын биелэлтэд хяналт тавина.

12.2 Энэхүү журмаар тогтоосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд Хорооноос холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

12.3 Энэ журмаар мэдээллийн санд мэдээлэл ирүүлэх үүрэг хүлээсэн этгээд заасан мэдээллийг тогтоосон хугацаанд, зохих маягт, стандартын дагуу үнэн зөвөөр, бүрэн нийлүүлээгүй нь тогтоогдвол мэдээллийн сангаас мэдээлэл авах эрхийг хязгаарлах хүртэл арга хэмжээг Холбоо авч болно.